



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.06.04 № А-1/2263
танай _____-ны № _____-т

**Тодруулгын хариу хүргүүлэх
тухай**

Тус газраас зарласан ЗТХЯ/20240101013 дугаартай XV.1.1.79 “Увс нуур-Улаангом чиглэлийн хатуу хучилттай авто замын эхний үе шат, 26.39 км /Увс/” УТ2402804371 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна. Үүнд:

| № | Сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулга | Тодруулгын хариу |
|---|--|--|
| 1 | БНХАУ-д өөрийн эзэмшлийн техник болохыг нотлох техникийн гэрчилгээ байдаггүй бөгөөд худалдан авсан НӨАТ-ын баримтаар баталгаажуулдаг тул техникийн материалыг хэрхэн шаардлагад нийцүүлэн илгээх талаар тодруулга өгнө үү. | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэгт заасны дагуу гадаадын этгээд оролцох эрхтэй бөгөөд Сангийн сайдын 2023 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам” болон тендер шалгаруулалтын зааварчилгааны дагуу ирүүлнэ. |
| 2 | ТШЗ-ны 19.1-д заасан инженер, техникийн ажилтнуудад тавигдах шаардлагын “ажилласан жилийн туршлага”-ын хугацаа нь заавал тухайн компанид ажилласан жил байх эсэх, тухайн компанид ажилласан хугацаанд тодорхой шаардлага байгаа эсэх | Ажилласан жилийн туршлагыг ТШЗ 19.2-т заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг буюу Төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгасан ажилтны сургууль төгссөн дипломын хуулбараар тооцно. |
| 3 | Монгол улсад нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй нөхцөлд ажилтны гадаадад мэргэжлээрээ ажилласан ажлын туршлагыг ямар баримтаар хүчин төгөлдөх гэж үзэх вэ? | ТШЗ 19.2-т заасны дагуу санал болгож буй ажилтан нь гадаад улсад сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулгын хамт ирүүлнэ. |

1324026139

Тендерт оролцогчоос ирүүлсэн тодруулгатай холбогдуулан тендерийн баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

- ТШЗ 26.1. “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Цаг: 09 цаг 00 минут” гэснийг “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр. Цаг: 09 цаг 00 минут” гэж;
- ТШЗ 26.2. “2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, Цаг: 09 цаг 10 минут” гэснийг “Огноо: 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр. Цаг: 09 цаг 10 минут” гэж тус тус өөрчлөв.

Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д дээрх өөрчлөлтийг тусгасан тендерийн баримт бичгийг шинэчлэн байршуулсан болно.

ДАРГА  Ц.БАТЗУЛ

